



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 1165

Улаанбаатар хот

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр
2017 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын
жагсаалт, 2017 он дамжин хэрэгжих ажлын
жагсаалтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.4 дэх заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 3/13 дугаар тогтоол, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны А/118 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтад оруулах өөрчлөлтийг нэгдүгээр, дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2017 он дамжин хэрэгжих ажлын жагсаалтад оруулах өөрчлөлтийг хоёр дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөрөнгө оруулалтын ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж ажиллахыг дүүргийн Засаг дарга Ж.Сандагсүрэнд үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдын Хурлын дэргэдэх Санхүү, эдийн засгийн ажлын хороо /Э.Батболд/-нд даалгасугай.



ДАРГА

Б.МӨНХЦЭЦЭГ

C:\Users\\Downloads\Өөрчлөлт-2007.docx

1180000217


Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 05 дугаар сарын
02-ны өдрийн 16 тогтоолын нэгдүгээр хавсралт



Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2017 онд
хийгдэх ажлын жагсаалтад оруулах өөрчлөлт

д/д	Оруулах өөрчлөлт
1	Хөрөнгө оруулалтын ажил, төсөвт өртөг 130.0 сая гэснийг хасах
2	Авто зам, зогсоол сайжруулах, байршил 3-р хороо /65-р сургуулийн баруун талын авто замаас 80-р цэцэрлэг хүртэл/, төсөвт өртөг 35.0 сая гэж шинээр нэмэх
3	Авто зам засаж сайжруулах, байршил 8-р хороо, /Баянхошууны авто замаас 67-р сургууль хүртэл/, төсөвт өртөг 10.0 сая гэж шинээр нэмэх
4	Хүндэтгэлийн хаалга /байршил 22-р хороо/ сэргээн засварлах, төсөвт өртөг 2.0 сая гэж шинээр нэмэх
5	Хуучин барилга буулгах /5-р хороо хуучин контор/, төсөвт өртөг 20.0 сая гэж шинээр нэмэх
6	Улсын баяр наадмыг дүүрэгт тэмдэглэх, төсөвт өртөг 63.0 сая гэж шинээр нэмэх

Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 05 дугаар сарын
02-ны өдрийн 1/65 тогтоолын хоёрдугаар хавсралт



Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2017 он
дамжин хэрэгжих ажлын жагсаалтад оруулах өөрчлөлт

д/д	Оруулах өөрчлөлт
1	Хур хогийг ачиж тээвэрлэх, байршил хороод, төсөвт өртөг 20.0 сая гэснийг хасах
2	Хур хог цэвэрлэх, тээвэрлэх, байршил 21-р хороо, төсөвт өртөг 10.0 сая гэж шинээр нэмэх
3	Хур хог цэвэрлэх, тээвэрлэх, байршил 26-р хороо, төсөвт өртөг 10.0 сая гэж шинээр нэмэх